

**ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ
ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2017 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН МЭДЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2017.10.04

Арвайхээр сум

Монгол Улсын Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” 2005 оны 67 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудаас 2017 оны 03 дугаар улирлын байдлаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдлын талаар ирүүлсэн дүн мэдээг нэгтгэн танилцуулж байна.

2017 оны 03 дугаар улирлын байдлаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг аймгийн Засаг дарга, ЗДТГ, 19 сумын Засаг дарга, ЗДТГ, аймгийн Засаг даргын дэргэдэх 24 агентлаг графикт хугацаандаа ирүүлэхээс Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, Стандратчилал хэмжил зүйн хэлтэс, Статистикийн хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Онцгой байдлын газарууд, Бүрд, Гучин-Ус, Өлзийт сумд мэдээ тайлангаа ирүүлээгүй тасалсан байна.

2017 оны 03 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж нийт 11702 өргөдөл, гомдол, санал ирүүлснээс өргөдөл 8799 буюу 75.1 хувь, гомдол 1379 буюу 11.7 хувь, санал 1524 буюу 13.0 хувийг тус тус эзэлж байгаагаас ирүүлсэн хэлбэрийн хувьд авч үзвэл бичгээр 8473 буюу 72.4 хувь, биечлэн буюу утсаар хандсан 3229 буюу 27.6 хувь байна. Төрийн байгууллага, албан тушаалтнуудад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн нийт 11702 өргөдөл, гомдол, саналын 11186 буюу 95.5 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 3160 буюу 27.0 хувийг холбогдох байгууллагад шилжүүлсэн, 512 буюу 4.3 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Нийт ирсэн 11702 өргөдөл, гомдол, саналын 538 буюу 4.6 хувь нь шилжилт хөдөлгөөнтэй холбоотой, 687 буюу 5.8 хувь нь материал, мөнгөн тусламж хүссэн, 25 буюу 0,21 хувь нь сургууль, курст суралцах, 71 буюу 0.6 хувь нь гэр, орон сууц хүссэн, 943 буюу 8.01 хувь нь ажилд орохыг хүссэн, 916 буюу 7.8 хувь нь тэтгэвэр тогтоолгох, 8513 буюу 72.75 хувь нь тусгай болон газрын зөвшөөрөл, жижиг, дунд

үйлдвэрлэл хөгжүүлэхэд шаардагдах зээл олгохыг хүссэн, иргэний баримт бичгийн зөрчил арилгуулах, залруулах, нөхөн гэрчилгээ олгохыг хүссэн зэрэг бусад асуудлаар хүсэлтээ тус тус илэрхийлсэн байна.

Аймгийн Засаг даргын 7 хоног бүрийн шуурхай хурлаар аймгийн Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн 70321111 утсанд хандаж буй иргэдийн гомдол, саналыг хэлэлцэн, холбогдох байгууллагын удирдлагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллаа.

2017 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсэж өргөдөл ирүүлсэн 61 иргэнд 7 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах төвд нийт 65 иргэн хандаж 61 өргөдөл, гомдол, саналыг хуулийн хугацаанд шийдвэрлэж 4 өргөдөл, гомдол, санал шийдвэрлэх шатандаа холбогдох байгууллагуудад шилжүүлээд байна.

Өвөрхангай аймгийн иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтнуудад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2017 оны 03 дугаар улирлын мэдээг нэгтгэн гаргаж, хавсралтаар хүргүүлэв.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2017.10.04

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт			Хугацаа болоогүй	Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн		
1	Аймгийн ЗДТГазар	154	134	22	-	20	87.01%
2	Агентлагууд	2929	2737	1915	-	192	93.44%
3	Сумд	8619	8319	1223	4	300	96.51%
Дүн		11702	11190	3160	4	512	95.62%

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДЭЭС НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ /ХЭЛБЭРЭЭР/

2017.10.04

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс:			
			бичгээр	Утсаар	Биечлэн	Бусад
1	Аймгийн ЗДТГазар	154	154	-	-	-
2	Агентлагууд	2929	1122	1789	18	-
3	Сумд	8619	7197	-	1422	-
Дүн		11702	8473	1789	1440	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛД ЗОНХИЛЖ БУЙ АСУУДАЛ

2017.10.04

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол 11702 ирсэн байна.	хүсэлт	8799	75.19%
		гомдол	1379	11.78%
		санал	1524	13.02%
	Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, нийгмийн даатгалт, байгууллагын үйлчилгээ үйл ажиллагаатай холбоотой асуудлууд	8522	72.82%	
	Хөдөлмөр эрхлэлт	943	8.05%	
	Тэтгэвэр тогтоолгох	916	7.82%	
	Материал, мөнгөн тусламж хүссэн	687	5.87%	
	Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой	538	4.59%	
	Гэр, орон сууц хүссэн	71	0.60%	
	Сургууль курст суралцах	25	0.21%	
<ul style="list-style-type: none"> • Аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн 70321111 утсанд 1789 иргэн хандаж, цаг үеийн шинжтэй мэдээллийг 1063 иргэнд өгсөн байна. • Арвайхээр, Уянга, Сант сумын ЗДТГ-т нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, газар өмчлөх, эзэмших хүсэлт, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, нийгмийн даатгалтай холбоотой нийт 1139 өргөдөл, гомдол ирүүлсэнийг холбогдох байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлсэн байна. Энэ нь бусад сумдтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа шалтгаан нь хүн ам олон, шилжилт хөдөлгөөн ихтэй байгаатай холбоотой байна. 				

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР